

МЭРИЛИН ХИККИГИЙН ҮЙЛЧЛЭЛ

ЗУУР! ЗҮҮДНЭЭСЭЭ

МЭРИЛИН ХИККИ



Зүүднээсээ

ЗУУР!

МЭРИЛИН ХИККИ

HOLD ON TO YOUR DREAM! (Mongolian)
by Marilyn Hickey

Copyright © 2017
by Marilyn Hickey & Sarah Bowling

Marilyn Hickey Ministries
www.marilynandsarah.org

Originally published in English as Hold On To Your Dream!
ISBN 1-56441-155-9

ЗҮҮДНЭЭСЭЭ ЗУУР!
Мэрилин Хикки
© 2018, Marilyn Hickey & Sarah Bowling

Библийн ишлэлийг: АРИУН БИБЛИ
© 2004, 2011, 2013 Ариун Бичээс Нийгэмлэг

Монгол улсад хэвлэв

ЗҮҮДНЭЭСЭЭ ЗУУР!

Чи ямар нэгэн сүнслэг зүүд юмуу үзэгдэл үзэж байсан уу? Би нойрон дундаа маш их зүүдлэдэг ч, зүүд болгоноо сохроор дагаж гүйгээд байдаггүй. Гэхдээ Бурхан бидэнд гайхамшигтай үнэнийг илчилдэг онцгой зүүд гэж байдгийг би мэднэ. Жишээлбэл би нэг удаа үүрийн 05:30-д сэрээд, Эзэн миний дотоод хүнд: “Иосеф, Иосеф” гэж шивнэж байхыг сонсож билээ. Хожим Иосефийн түүхийг судлалал, Эзэн надад сүнслэг зүүдний талаар гайхмаар сайхан зүйлийг ойлгуулсан юм. Би энэ талаар уншихдаа асгартлаа уйлж билээ.

Бурхан Иосефт ер бусын амьдрал зэхсэнээ зүүдлүүлэн илчилжээ. Бурхан чамд ч бас төгс төлөвлөгөө зэхсэн. Бурхан үүнийгээ чамд заавал зүүдээр илчлэхгүй байж болох ч, тэр төлөвлөгөөг биелүүлэх сүнслэг хүслийг

ямар нэгэн аргаар заавал өгнө. Иосефийн амьдралыг сайтар судласан хүн өөрийнхөө амьдралын “сүнслэг зүүдийг” таних амин чухал түлхүүрийг олно. Бурхан чамд зориулж сүнслэг ертөнцөд хадгалсан төгс төлөвлөгөөг чи амьдрал дээр бодитоор биелүүлнэ.

Иаков гэдэг залуу Рахел гэдэг бүсгүйтэй гэрлэснээр, дундаас нь Иосеф төржээ. Гэтэл Рахелийн аав зальхай Лабан Иаковыг дөнгөөд, Рахелийн эгч - том охин Леатайгаа гэрлүүлчихэв. Иаков Рахелийн төлөө Лабанд олон жил хүчин зүтгэсэн байлаа. Гэтэл хадам аавдаа дөнгүүлж, буруу хүүхэнтэй гэрлэсэн Иаков зүрхний хайрт Рахелтайгаа гэрлэхийн тулд дахин олон жил Лабанд хүчин зүтгэв. Ийнхүү Лабан Иаковыг байн байн дөнгөсний эцэст Эзэн Иаковт онцгой арга зааж өгсний ачаар тэрбээр Лабаны гэрээс явахдаа бэл бэнчинтэй, өнөр бүлийн тэргүүн болсон байв.

Иаковын их гэргий Леа баахан хүүхэд

гаргатал, харин Рахел хүүхэд олсонгүй. Үр хүүхэдгүйгээсээ болж олон жил шившиг болсон Рахел цөхрөнгөө баран Эзэн рүү: “Надад үр хүүхэд заяагаач. Үгүй бол би үхье” (Эхлэл 30:1) гэж хашхирчээ. Гэтэл Эзэн түүний залбиралд хариулан, “хэвлийг нь нээв.” Рахел хүүхэд олж, хүү төрүүлээд “Эзэн миний зэмлэлийг зайлуулсан юм. Тиймд би хүүгээ Иосеф хэмээн нэрлэе” гэжээ.

Иосеф гэдэг нь “нэмэх” гэсэн утгатай, маш сайхан нэр. Рахел яагаад ууган хүүгээ Иосеф гэж нэрлэв? Яагаад гэвэл тэр хоёр дахь хүүхдээ төрүүлэх санаатай байв. Рахел гэдрэг суугаад: “Би хүсээд байсан ганц ялалтаа байгуулчихлаа” гэж хэлээгүй. Харин ч хүүгээ Иосеф хэмээн нэрлэхдээ, “Эзэн надад дахиад хүү өгөх болно” гэжээ. Рахел үнэхээр дахиад Бениамин гэдэг хүүтэй болдог.

Иосеф ёстой л аав, ээжийнхээ нар байв. Хүү Эзэнийг хайрладаг шигээ аав ээжээ

хайрлана. Харамсалтай нь эцэг нэгтэй ах нар нь тэс өөр хүмүүс байв: Тэд Эзэнийг ч, Иосефийг ч хайрласангүй. Нэг удаа Иосеф ах нарынхаа талаар аавдаа алтан хошуу хүргээд, тэдний зэвүүг бадраажээ. Аргагүй л дээ, ховон хошуунд хэн дуртай байхав. Гэтэл аав нь амины ганц хүүдээ (Иосефт) өнгө өнгөөр алагласан, жигтэйхэн сайхан дээл бэлэглэсэн нь “дарин дээр давс” гэгч болжээ. Би анх энэ дээлний талаар уншихдаа, зүгээр л нэг бэлэг гэж бодсон юм. Гэтэл үгүй байсныг нь - энэ дээлний ач холбогдлын талаар 1Шастир 5:1-2-аар ишлэлээс олж мэдэж билээ:

“Израилийн ууган хүү Реубений хөвгүүдийг тоочвол, (Реубен ууган хүү байсан боловч тэр эцгийнхээ орыг бузарласан тул түүний ууган хүүгийн эрх нь Израилийн хүү Иосефын хөвгүүдэд өгөгдсөн юм. Иймээс тэр удмын бичигт ууган гэж бичигдсэнгүй. Хэдийгээр Иуда ах дүүсээ давамгайлж, түүнээс удирдагч

гарсан боловч ууган хүүгийн эрх Иосефт хамаатай юм.)”

Аав нь Иосефт зүгээр нэг өнгө өнгөөр алагласан дээл бэлэглээгүй, харин ууган хүүгийн эрхийг өвлүүлжээ. Иосеф ууган хүү биш учраас, ууган хүүгийн эрхийг өвлөх учиргүй байв. Тэгвээс Иосеф аавыгаа өөд болох үед гэрийнхээ тахилч болох ёстой байлаа. Ер нь бол айлын ууган хүү л ууган хүүгийн эрхийг уламжлан өвлөдөг байжээ. Гэтэл аав нь Иосефийг сүнслэг зүйлст хараатай хүү гэж үзсэн тул дээл бэлэглэхдээ, үндсэндээ “Иосеф, чи бол намайг залгамжлах өрхийн тэргүүн” гэж хэлжээ. Ингээд ах нарынхаа хар дансанд хэдийн багтаад байсан Иосеф бүр өнгөрөв өө.

Өнгө өнгөөр алагласан дээл нь чухам юуг билэгдэж байсан талаар хэд хэдэн сонирхолтой баримт хэлье. Библи дахин төрсөн итгэгч бүрийг бидний итгэмжтэй Хаан

бөгөөд Тахилч болох Есүс Христ доторх хаад бөгөөд тахилч нар гэдэг. Хуучин гэрээний тахилч нар хүрэн улаан, цэнхэр, нил ягаан гэсэн өнгө өнгөөр алагласан дээл өмсдөг байв. Эдгээр өнгө нь бидний хувьд дараах зүйлийг илэрхийлнэ: Хүрэн улаан нь чамайг бүхий л зөвт бусаас цэвэрлэхээр урссан Есүсийн цусыг төлөөлнө. Цэнхэр нь бурханлаг чанар, Бурханы Үгийг төлөөлнө. Нил ягаан өнгө нь хүрэн улаан, цэнхэр хоёрыг хольж байж гардаг бөгөөд хаад язгуурыг билэгддэг.

Энэ нь юу гэсэн үг вэ? Энэ нь чи Есүсийн цусыг Бурханы Үгийн бурханлаг чанартай нийлүүлбэл, хаад язгуурын хүн шиг - Есүс Христ доторх хаан бөгөөд тахилч мэт байна гэсэн үг. Үүнийг Илчлэл 12:11 гайхалтай сайхан хэлдэг: “Тэд түүнийг Хурганы цус, өөрсдийн гэрчлэлийн үгээр ялжээ. Тэд үхэн үхтлээ амиа хайрлаагүй юм.”

Яагаад зарим Христэд итгэгч нар Есүсийн

өгсөн эрх мэдэлд эзэн болж чаддаггүй вэ? Яагаад гэвэл тэд Бурханы Үгийн бурханлаг чанарыг Есүсийн цэвэрлэгч цустай хольдоггүй. Мэдээж бид авралаар дамжин цэвэрлэгдсэн ч, цэвэр байдлаа өдөр бүр Бурханы Үгээр тордож явах ёстой юм. Хурганы цус, Бурханы Үг хоёр чамайг Христэд итгэдэг хүн шиг хүн болгож, бат зогсоож, диаволыг ялах хүчийг өгч, Есүс Христ дотор хаан мэт байлгана.

Өөрсдийнх нь өмнүүр орж, эрх мэдлийн дээлийг гардаж авсан Иосефт ах нар нь хорсов. Тэгтэл Иосефийг дээлээ хүлээн авсны дараа Эзэн түүнийг улам зоригжуулах мэт зүүд зүүдлүүлжээ.

“Биднийг тариалангийн талбайд сүрэл боож байтал миний боосон сүрэл босоод зогсчихов. Гэтэл үзэгтүн, та нарын боосон сүрэл миний сүрлийг тойрон зогсоод, түүнд мөргөцгөөв гэж ярьжээ” (Эхлэл 37:7).

Иосеф ах нарынх нь сүрэл өөрийнх нь сүрэлд мөргөж байна гэж зүүдлэнгүүтээ яасан? Шууд ах нартаа ярьчихсан. Тэртэй тэргүй Иосефт дургүй байсан ах нар нь одоо түүнд бүр хилэгнэсэн. Эхлээд Иосеф тэднийг ховлосон, дараа нь ууган хүүгийн эрхийг нь булаасан, эцэст нь тэднийг өөрт нь мөргөж байна гэж зүүдлэсэн. Тэд Иосефийг нэг нүдээрээ ч харахаа болив. Тэгтэл бүр баларсан юм болж, Иосеф дахиад нэг зүүд зүүдлэв. Энэ удаа нар, сар, одод түүнд мөргөж байх юм гэнэ. Иосеф бас л тэсэлгүй, гэрийнхэндээ зарлачихав.

Чамайг дахин төрсөн итгэгч болох үед чамтай маш чухал явдал тохиолддог: Чи Есүс Христтэй хамт Бурханы өв залгамжлагч болдог. Чи тэнгэрийн Бурханых болдог. Эзэн сүнслэг ууган хүүгийн эрхтэй хүмүүсээр дамжуулж газар дээр төлөвлөгөөгөө биелүүлэхийн тулд тэднийг дууддаг. Тиймээс

л Эзэн тэдэнд сүнслэг зүүдийг өгдөг юм.
Эзэн Есүс Христ эргэж ирэх хүртлээ ийм арга замаар хүмүүсээ хөдөлмөрлүүлж, үр жимстэй байлгадаг ажээ. Эзэн чамд зорилгоо өгсөн үү? Тэр зорилгыг чинь л “сүнслэг зүүд” гээд байгаа юм шүү. Чи Эзэний дуудлагыг заавал унтаж байхдаа үзэж харах юмуу зүүдлэх албагүй. Эзэнээс ирсэн онцгой төлөвлөгөөг биелэл болгох зүрхний хүсэл чинь л чиний зүүд юм. Хэрэв чамд зорилго байхгүй бол, олж ав.

Зүүд нь ууган хүүгийн эрхийн өмнө биш, харин дараа нь ирдэг. Хэрэв чи Есүс Христийг дуудаж, ууган хүүгийн эрхээ хүлээн авч, Түүнийг амьдралынхаа Эзэн болгосон бол, Есүс чамд үзэгдэл (дуудлага) зэхсэн л байгаа. Харин сүнслэг зорилгыг өдөр бүрийнхээ амьдралд хэрэгжүүлэх нь Христэд итгэгч чиний үүрэг мөн. Тэгвээс хийсэн бүхэн дээр чинь Бурханы хүчирхэг мутар оршин байхыг чи харна.

Бурхан Иосефт сүнслэг зүүд өгсөнд ах

нар нь түүнийг үзэн ядсан. Иосеф зүүдээ ах нартаа яриад, дараа нь аавдаа ярьтал аав нь ч дургүйцэв. Эхлээд аав нь “Хүний санаанд оромгүй юм ургуулж боддог, янзын хүүхэд шүү” гэж бодсон ч, яваандаа эргэцүүлэн шүүгээд, цаанаа гүн учиртай байж юуны магад хэмээн битүүхэн итгэжээ. Иаков хүүгийнхээ зүүдийг сүнслэг ухаанаар шүүсэн бол, хөвгүүд нь ялгаж ухамсарлах нь бүү хэл, яаж дүүгээ далд оруулах талаар хуйвалджээ.

Нэг өдөр ах нар нь ная гаруй километрийн зайтай байдаг Дотан хот руу тууварт явж, Иосеф гэртээ үлджээ. Хөвгүүд нь яваад хэл чимээгүй удсан тул Иаков арга буюу араас нь Иосефийг явуулав. Иосеф Дотанд хүрээд, ах нараа олж очтол ах нар нь түүнийг үзээд: “Хараач, манай зүүдлэгч!” хэмээн үгээр иджээ.

Дэлхий ч бас Христэд итгэдэг хүмүүсийг ингэдэг бус уу? Тэд: “Өө, нөгөө мөрөөдчихсэн

Есүсийнхэн! Элийрэхээ болиод, хөрсөн дээрээ бугаасай!” гэдэг. Дэлхий чиний зүүдийг ингэж л хүлээж авах учраас, бэлтгэлтэй бай. Тэд чамайг ойлгохгүй. Зарим нь бүр галзуу гэнэ. Яагаад? Есүс Христийн Сайн мэдээг даян дэлхийд хүргэж, Бурханы төлөвлөгөөг газар дээр биелүүлж, чамайг дэлхий дээр байхад Есүс Христ эргэж ирнэ гэдэгт итгэсний чинь төлөө тэр. Үүнийг чинь дэлхий солиорол л гэнэ. Бурханы урсгалд нэгдээгүй хүмүүс сүнслэг зүүдийг хэзээ ч ойлгохгүй!

Ах нар нь сүнслэг зүүдийг ойлгоогүй учраас, Иосефийг ирэхээр нь барьж аваад, өнгө өнгөөр алагласан дээлийг нь тайлжээ. Дүү нь тэднийг захирна гэхээс тэд зэвүүцэж, дээлийг нь хүртэл занаад: “Наад дээлийг нь тайлж ав! Энэ яахаараа биднийг захирдаг юм” (Эхлэл 37:23) гэжээ.

Иосефийн ах нар дүүгийнхээ эрх мэдлийг үзэн ядсан шиг диавол ч Есүсийн чамд өгсөн эрх

мэдлийг үзэн яддаг тул чинийх болгохгүйн төлөө бүхнийг хийнэ. Дьявол тэр эрх мэдлийн хүчин чадлыг мэддэг учраас, чамд мэдүүлэхгүйн тулд бүхнийг хийнэ. Ах нар нь Иосефийг дээлээс нь салгахдаа эрх мэдлийг нь үгүй хийчихлээ гэж санасан ч, үүндээ ханасангүй.

Тэд эхлээд Иосефийг нүхэнд хаяснаа дараа нь тэр нутгаар дайрч явсан Мидианы жинчдэд боол болгон зарж орхив. Тэгээд амьтан алж, цусанд нь Иосефийн дээлийг базаад, аавдаа авчран үзүүлээд: “Аав аа, үүнийг үзээч! Иосефийнх болтой! Эвий минь, түүнийг зэрлэг амьтан хөнөөсөн болтой” гэж хэлжээ. Үүгээр тэдний хувьд энэ түүх дуусав.

Ах нар нь Иосефийг дээлнээс нь салгасан ч, зүүднээс нь салгаагүй! Тиймээс Бурханаас ирсэн үзэгдэл, зүүдийг тээх нь ямар чухал болохыг харж байна уу? Иосеф байр сууриасаа хагацсан ч, зорилго, дуудлага нь ямар ч нөхцөлд мөхөлгүй, түүний дотор

лугшсаар байжээ. Тэрээр итгэлээ нөхцөл байдлаас том зүйл дээр зоосон бөгөөд Бурхан ийм дайвшгүй итгэлтэй итгэгчийг л үйл хэрэгтээ хүчин зүтгүүлдэг юм.

Иосеф боол болж, сүүлдээ Египетийн аюулгүйн албаны дарга Потифарын зарц болсон ч, зүүдээ хаясангүй. Иосеф юу ч хийсэн хичээнгүй хөдөлмөрлөж, дотроо байгаа Бурханы дуудлагыг чимээгүй тордсоор байв. Тиймээс ч Бурхан түүнийг ерөөжээ. Бурхан Иосефийг төдийгүй, Иосефийн ачаар Потифарыг ч ерөөв. Иосеф хоосон зүүдлэгч биш, маш хөдөлмөрч хүн байв. Бурхан ч ажил хөдөлмөрөөр дамжуулж алсын хараагаа биелүүлдэг юм. Чи “тэнгэрийн бодолтой” ч, үүнийгээ ажил хэрэг болгодоггүй итгэгч хүмүүсийг мэдэх л байх. Тэд зүүд тээгч нар байж болно. Гэхдээ зүгээр л мөнгөн үүлэн дунд хөвөөд, эрдэнийн зүйлээр бөөлжихийг л хүсдэг хүмүүс. Гэтэл ажил гэдэг ийм

байдаггүй. Хичээнгүй хөдөлмөртэй гагнагдаж байж л сүнслэг зорилго биелдэг юм.

Иосеф сайн ажилласан тул Эзэн өмнө нь алхаж, Потифарын тааллыг хүртээжээ. Амьдрал одоо л нэг цэгцрэв. Гэтэл яг энэ үеэр диавол Иосеф руу аймшигтай халдахдаа, Потифарын гэргийг гар хөлөө болгожээ.

Тэр хүүхэн хөдөлмөрч, залуухан сайхан Иосефт татагдаж, зогсоо зайгүй хоргоох болов. Иосеф ч түүнийг эрс эсэргүүцэж байсан ч, тэр эмэгтэй санасандаа хүрч байж санаа амардаг нэгэн байв. Иосефийг аргандаа оруулж дийлэхгүйгээ ухаарсан тэр хүүхэн гэрийнхэнийгээ эзгүй хойгуур Иосеф дээр хүрч очоод: “Надтай унтаач” гэжээ. Үнэн шулуухан. Иосеф цочирдсондоо зугтсан ч, эмэгтэй хувцсаас нь зуураад авч үлджээ.

Тэгээд нөгөөх чинь Иосефийн хувцсыг нөхөртөө үзүүлээд, Иосеф намайг хүчиндэх гэж оролдсон, би л журамтай, авхаалжтай

эмэгтэй тулдаа хашхирч, гэмт хэргийн баримт болох хувцсыг нь авч үлдлээ хэмээн худлаа ярьдаг. Ийнхүү Потифарын залуу зарцын хувь тавилан харанхуйлж, тэрбээр хоёр дахь удаагаа хувцсаа алдав.

Хилэгнэсэн Потифар Иосефийг Фараоны шоронд хаяжээ. Тэр үед Иосеф: “Ай хөөрхий, амьдрал хатуу! Ууган хүүгийн эрхийг өвлөлөө, зүүд зүүдлэлээ, илчлэл авлаа, соёрхол хүртлээ - гэсэн ч боол болов би. Боолоор барахгүй, үнэнээр явсныхаа төлөө шоронгийн хадаас болов” хэмээн эмгэнэх бүрэн эрхтэй байсан ч, Иосеф тэр их зовлон дундаа хэлээ хазаад, шүдээ зуугаад, зүүдээ хаялгүй, тас зуурчээ.

Иосеф тийм шийдэмгий байсан учраас, Бурхан түүний төлөө гайхамшгийг үйлдсэн юм: “ЭЗЭН Иосефтой хамт байж, түүнд энэрэл хайр үнэнээр хандаж, тэрээр шоронгийн ахлагчийн нүдэнд тааллыг олжээ”

(Эхлэл 39:21).

Чамайг хаа ч байсан Бурхан чамд тэнгэрлэг хүчийг өгч чадна гэдгийг чи мэдэх үү? Түүний өгсөн зүүдээс чангахан зуур. “Шоронд ч хүртэл үү?” Тийм ээ!

Хэрэв чи нөхцөл байдлаа дагаж гулжигнаад байх юм бол, нөхцөл байдлынхаа хохирогч болно. Харин бурханлаг дуудлага, зүүдэндээ бүх хүчээрээ бүрэн зориулагдах юм бол, нөхцөл байдал чинь чиний итгэлийн хохирогч болно. Бурхан чамд тааллаа өгдөг. Бурхан Иосефийг шоронд байхад нь таалан соёрхож, тэрбээр бусад хоригдлуудыг захирах болжээ.

Бурхан Иосефийг санаанд оромгүй аргаар ерөөж, бусдын зүүдийг тайлах чадвар өгөв. Иосеф өөртэй нь хамт хоригдсон хоёр хоригдлын зүүдийг тайлахдаа, энэ чадвараа олж мэддэг.

Нэг хоригдол нь Иосеф дээр ирээд зүүдээ ярьжээ: “Тэгээд ахлах сөнч зүүдээ Иосефт

ярьсан нь —Миний зүүдэнд, харагтун, өмнө минь усан үзмийн мод байв. Тэр мод гурван мөчиртэй бөгөөд ургаж дэлгэрээд усан үзэм боловсорчээ. Тэгээд миний гар дээр Фараоны аяга байх ба би усан үзэм авч, Фараоны аяганд шүүсийг нь шахаж хийгээд, тэр аягаа Фараоны гарт өгч байлаа” гэв (Эхлэл 40:9-11).

Гэтэл Иосеф зүүдийг нь тайлав: “Фараон гурван өдрийн дотор тэргүүнийг тань өргөж, хуучин албанд тань дахин оруулна. Тэгээд та урьд түүний сөнч байх үедээ хийдэг байсан ёсоор Фараоны аягыг дахин гарт нь өгөх болно” (Эхлэл 40:13).

Үүнийг сонссон нөгөө хүн учиргүй баярлав. Тэрбээр гурав хоногийн дотор буцаад Фараоны ахлах сөнч болов. Энэ нь түүнийг шоронгоос гаргах боломж байж магадгүй гэж бодоод, нөгөө хүнээс Иосеф: “Фараон дээр очихдоо, намайг дурсаарай” гэж гуйтал, нөгөө хүн ч зөвшөөрөв.

Иосефийн зүүд тайлах чадварыг үзсэн хоёр дахь хоригдол нь Иосефт мөн зүүдээ ярьжээ: “Түүнийг сайнаар тайлахыг ахлах талхчин хараад, Иосефт —Би бас зүүдэндээ үзсэн нь, харагтун, миний толгой дээр цагаан талхтай гурван сагс байв. Дээд талын сагсанд нь Фараонд зориулж жигнэсэн янз бүрийн жигнэсэн бүтээгдэхүүн байлаа. Гэтэл шувууд миний толгой дээрх сагснаас түүнийг авч идэж байлаа” (Эхлэл 40:16-17).

Иосеф тэр даруй тэр хүний зүүдийг тайлав: “Иосеф —Түүний тайлал гэвэл, гурван сагс нь гурван өдөр юм. Гурван өдрийн дотор Фараон тэргүүнийг тань биеэс чинь өргөн авч модонд өлгөхөд шувууд махыг чинь идэх болно гэв” (Эхлэл 40:18-19). Гайхмаар! Хөөрхий хоригдол зүүдээ асуусандаа амаа бариа байх даа.

Иосефийн тайлсан үйл явдал хэрхэн биелсэнийг Эхлэл 40-ээр бүлгийн дараа

дараагийн ишлэлд өгүүлдэг. Эхний хоригдол Фараоны ахлах сөнчийн ажилдаа буцаж орсон бол, хоёр дахь нь модноос дүүжлүүлэн цаазлуулжээ. Энэ хооронд Иосеф өөрөө суллагдах эсэхээ ч мэдэхгүй, шорондоо үлдэв. Ахлах сөнч Иосефийг таг мартаад, хоёр жил өнгөрчээ.

Яг энэ үед би: “Бурхан минь, Иосеф ийм байдлыг яаж тэсэв ээ? Тэр чинь хүн шүү дээ!” гэж дуу алдсан юм. Тэгтэл Эзэн надад Иосефийн сэтгэлийн хүч хатын цаад учрыг харуулав: Тэр зүүднээсээ зуурсаар байжээ. Зүүдтэй хүмүүс нөхцөл байдлаа үл харгалзан, цаанаасаа л тэсч тэвчээд байдаг. Би Иосефийг зүгээр л сэтгэлийн асар их хаттай хүн гэж бодсон ч, энэ нь түүний зан чанарын хүч хаттай огт холбоогүй байв. Тэрээр хүний хүчээр хэзээ ч тэсэхгүй байсан. Эзэн: “Би чамд зүүд өгөхдөө, тэсч тэвчих хүчийг нь бас өгнө” хэмээн айлджээ. Иосефийн хүч хат нь

Эзэнээс ирсэн байв.

Тэгтэл хоёр жилийн дараа өөр нэг хүн унтаж байхдаа зүүд үзжээ. Тэр нь Фараон байв. Энэ гайхмаар үйл явдлыг Эхлэл 41:1-7 дээр бичжээ: “Бүтэн хоёр жилийн дараа Фараон нэгэн зүүд зүүдлэв. Харагтун, Фараон гол дээр зогсож байх юм. Тэгтэл, харагтун, тарган сайхан долоон үхэр голоос гарч ирээд нугад бэлчиж байжээ. Харагтун, түүний хойноос бас өөр туранхай муухай долоон үхэр голоос гарч ирээд голын эрэг дэх нөгөө үхрүүдийн дэргэд зогсжээ. Нөгөө туранхай муухай үхрүүд нь мөнөөх тарган сайхан долоон үхрийг идчихэв. Тэгээд Фараон сэржээ. Тэрээр эргэж унтаад, хоёр дахь удаагаа зүүдэлжээ. Харагтун, нэгэн ишнээс өтгөн сайхан долоон тариан түрүү гарч иржээ. Бас түүний дараа дорнын салхинд хатаж хорчийсон долоон нарийхан түрүү гарч иржээ. Тэгээд тэр нарийхан долоон түрүү

нь өтгөн бүтэн долоон түрүүгээ залгичихав. Фараоныг сэртэл, харагтун, тэр нь зүүд байлаа” (Эхлэл 41:1-7).

Фараон үзсэн зүүдэндээ сэтгэл чилээж, тайллыг нь хүсэв. Хамаг л идтэй шидтэй, мэргэлдэг түргэлдэг хүмүүсээ дуудсан боловч, хэн ч утгыг нь тайлж чадалгүй, дэмий л ангайлаа. Гэтэл ахлах сөнч гэнэт: Байзаарай Фараон минь, таны зүүдийг хэн тайлахыг би мэдлээ. Тэр миний зүүдийг бас нэг хүний зүүдийг яг тайлсан. Тэр таны ч зүүдийг тайлна. Тэр хүн таны шоронд хоригдож байгаа Иосеф гэдэг хүн. Хоёр жил нүдэнд харагдахгүй зүйлээс буюу Бурханы өгсөн зүүдээс зуурсан Иосеф ийнхүү Фараоны зүүдийг тайлахаар өмнө нь зогсов.

Түүнийг шоронгоос гаргаж, хир буртаг, үс ноосноос нь салгаж, гоёж гангалаад хааны өмнө авчирчээ. Иосеф шоронгийн хувцсаасаа салаад, Фараоны өмнө хэн ч биш юм шиг

зогссон гэж бодож байна уу? Яалаа гэж. Тэр Фараоны өмнө эрх мэдэлтэй - нөхцөл байдалдаа найддаггүй, зүүдтэй (дуудлагатай) хүн шиг зогссон. Ингэж Иосефийн дотор лугшиж байсан зүүд нь цэцэглэж эхлэжээ. Сургаалт үгс 18:16 дээр “Хүнд өгсөн бэлэг сэлт хаалгуудыг нээх. Хүндэт нэгэнтэй ч хүртэл учруулах” гэдэг. Бурханы өгсөн бэлэгийг хэзээ ч бүү дорд үз. Иосеф зүүдээ дорд үзэлгүй, зууран зуурсаар жинхэнээсээ хүндтэй хүний өмнө зогсжээ.

Тэгэхээр Иосеф Фараоны өмнө зогсох үед хаан түүнээс: “Намайг чилээсэн зүүдийг чи үнэхээр тайлж чадах уу?” гэж асуув. Гэтэл Иосеф зүүднийх нь тайллыг нэгт нэгэнгүй хэлжээ: “Иосеф, Фараонд ‘Фараон таны зүүд чинь нэг л юм байна. Бурхан Өөрийн хийх гэж байгаа зүйлийг Фараонд үзүүлжээ. Долоон сайхан үхэр бол долоон жил, долоон сайхан түрүү нь бас долоон жил юм. Эдгээр

зүүд нь нэг юм. Тэдний хойноос гарч ирсэн долоон туранхай, муухай үхэр нь долоон жил юм. Мөн дорнын салхинд хатаж гандсан, хорчгор нарийхан долоон хоосон түрүү нь өлсгөлөнгийн долоон жил юм. Бурхан үйлдэх гэж байгаа зүйлээ Фараонд үзүүлсэн гэж Фараонд миний хэлсэн үг бол энэ юм. Харагтун, Египетийн нутаг даяар маш өнтэй сайхан долоон жил болж, дараа нь ган зудтай долоон жил залгаж, Египетийн нутагт өнтэй сайхан байсан бүхэн мартагдаж, нутаг орныг өлсгөлөн туйлдуулах болно. Энэхүү өлсгөлөн нүүрлэсний дараа маш хүнд хэцүү болох учир тэр нутагт өнтэй сайхан байснаас танигдах юм юу ч үгүй болно. Фараон та тэр зүүдийг хоёр дахин зүүдэлсэн нь Бурханаас энэ нь тогтоогдсон гэсэн үг бөгөөд Бурхан үүнийгээ даруй үйлдэх болно' гэжээ" (Эхлэл 41:25-32).

Ямар мундаг тайлал вэ? Гэтэл Бурхан Иосефт хааны зүүдийг тайлах чадварыг өгөөд

зогсохгүй, энэ гамшгаас хэрхэн урьдчилан сэргийлэх цэц ухааныг ч өгчээ.

Иосеф: “Фараон минь, би танд нэг төлөвлөгөө хэлье. Та улс даяар түшмэдүүдийг томилон, арвин ургацтай жилүүддээ баялгийнхаа тавны нэгийг хураагаад байвал, гамшгийн жилүүдэд ч хоол хүнстэй байна” гэжээ. Иосефийн ухааныг биширсэн Фараон Иосефийг ивээлдээ авч, хувь тавилан ч Иосеф руу мишээв.

Фараон: “Энэ хүн үнэхээр Бурханы Сүнстэй эвсдэг ажээ” гээд, Иосефийг түүний зүүдлээ ч үгүй хүндэтгэлийн байр сууринд гаргажээ: “Чи миний өргөөг захир. Миний ард түмэн бүгдээрээ чиний амаар байг. Би зөвхөн хаан ширээнд сууж байгаагаараа чамаас илүү гэв. Фараон —Харагтун, би чамд Египетийн бүх газар нутгийг захируулна гэж Иосефт хэлээд ...” (Эхлэл 41:40-41).

Фараон Иосефт бас зотон даавуун дээл

өгчээ. Иосеф дээлээ алдах биш, харин дээлээ нэмж эхлэсэн нь юутай ерөөл вэ.

Бурханаас ирсэн зүүдээ (дуудлагаа) алдахгүй байх нь ийм л чухал байдаг. Иосефт алдъя гэвэл алдах боломж зөндөө байсан. Гэхдээ Иосеф тэнгэрийн Ааваа дэндүү сайн мэддэг, Түүнд дэндүү их найддаг байжээ. Тэр Бурханы ганхашгүй амлалтад итгэсэн учраас, гуйвшгүй итгэлтэй байв. Зүүдээ (дуудлагаа) нөхцөл байдалдаа алдалгүй, лав зуур. Чи Бурханы Үг дээр зогсохоор шийдбэл, нөхцөл байдлаа сэгсэрч хаяна. Тэгээд (шаардлагатай бол) шийдвэр дээрээ мөнхөд зогссоор байвал, зүүд чинь мөнхөд хүлээлгэлгүй, биелнэ. Бурхан зүүдэн дээрээ бат зогсоод: “Миний Бурхан чадна аа!” гэж хэлдэг эрчүүд, эмэгтэйчүүдийг хайж байдаг.

Гайхмаар! Дээд зэргийн зотон даавуун дээлтэй, хүзүүндээ алтан гинжтэй Иосеф Фараоны ерөнхий сайд болжээ. Хэдхэн

цагийн өмнө шоронгийн хувцастай,
цээжиндээ зүүд тээсэн хоригдол байсан
Иосеф өдгөө нөхцөл байдал нь орвонгоороо
эргэхийг нүдээр үзэв.

Бурханаас өгөгдсөн зүүдийг тээдэг хүмүүс
хэзээд зөв хандлагатай байдгийг чи мэдэх үү?
Иосеф өнөөгийн Христэд итгэдэг хүмүүсийн
төсөөлж ч чадахааргүй зовлонт арван гурван
жилийг туулахдаа, зөв хандлагаараа цэх
зогсчээ. Тэр боол байхдаа ч, ерөнхий сайд
болоод ч зөв хандлагаа гээгээгүй. Иосеф
бусдад зүүдээ тариалсан учраас, өдгөө
өөрийнхөө зүүдний ургацыг хураажээ. Бид
бусдад зүүд (мөрөөдөл) тариалдаггүй учраас,
өөрийнхийгөө ч хураадаггүй.

Иосеф гэрлээд үр хүүхдээ нэрлэхдээ ч
зөв хандлагаа харуулдаг. Гэргий нь түүнд
хоёр хүү гаргаж өгөхөд, Иосеф хөвгүүдээ
Манассе, Ефраим гэж нэрлэдэг. Манассе нь
“мартуулсан” гэсэн утгатай бол, Ефраим нь

“Эзэн намайг таатай газраа өсгөн үржүүлсэн” гэсэн утгатай юм. Сайхан биш үү? Иосеф:

“Сорил, шалгуур намайг мөлжсөн ч, Бурхан хэзээд сайн. Тэр намайг ерөөж, зовлонг минь мартуулж, одоо үр жимстэй болголоо” гэжээ.

Иосеф хорсож гомдохдоо, шинэ эрх мэдлээ урвуулж болох байсан. Тэр: “Одоо л өшөөгөө авдаг хэрэг. Адилтай бол адилтай!” гэж хэлж болох байсан ч, тэгээгүй. Бурханлаг зүүдтэй хүмүүс алсын хараатайгаа эгнэсэн бурханлаг зан чанартай байдаг.

Хүмүүс: “Уучилж болно оо, гэхдээ мартаггүй” гэдэг. Ямар сайхан сэтгэл вэ? Тийм үү? Үгүй ээ, энэ буруу. Уучлах нь тэнгэрлэг боловч, мартах нь ч бас тэнгэрлэг зүйл гэдгийг чи мэдэх үү? Итгэлээр уучилж, Эзэнээр хорслоо мартуул. Эзэн Иосефт мартуулсан бол, чамд ч мартуулна.

Иосефийн хэлснээр Египетэд хачин сайхан долоон жил ирэв. Библи “маш арвин

ургац гарчээ” гэдэг. Газар үр шимээ өгч, арвин их ургац хайрлахад, хүмүүс түүнийг нь үрэн таран хийлгүй, Иосефт зааж өгсөн Бурханы цэц ухааны дагуу нөөцлөн хураажээ. “Далайн элс шиг” их эрдэнэшиш ургасныг нь өлсгөлөнгийн жилүүдэд зориулан хадгалжээ.

Элбэг баян долоон жил төгсөж, улс орныг гамшгийн долоон жил дайрав. Хатуу хөтүү нөхцөл байдал хэнийг ч өршөөлгүй дайрч, Иаковын нутгийг ч нэрвэв. Иосеф ард олныг өлсгөхгүйн тулд хоол хүнс хувиарлаад завгүй байх хооронд аавынх нь гэр бүл хоол хүнсээ баржээ. Канаанд өлсгөлөн нүүрлэж, Иаков хөвгүүдээ Египет рүү илгээхээр болов. Тэд Египетэд хоол хүнс байгааг сонсчээ.

Иаковын хөвгүүд хоол хүнс олж ирэхээр Египетийг зориод, Иосефийн ажиллаж байгаа хүнсний агуулах дээр очжээ. Иосеф ах нараа шууд таньсан боловч, өөрийгөө илчлээгүй учраас ах нар нь түүнийг таньсангүй. Тиймээс

нэгэнтээ Иосефийг “Зүүдлэгч!” хэмээн шоолж байсан ах нар нь түүний өмнө гүнээ мэхийн ёсложээ. Арван гурван жилийн өмнө Бурханы Иосефт өгсөн зүүд ийнхүү биелэв.

Иосеф ах нараа таниад, хувийн атаа жөтөөгөө биелүүлэхээр санасан уу? “Ингээд та нар надад мөргөчихлөө!” гэж бодсон уу? Үгүй. Зүүд нь хүний атгаг сэтгэлийн төлөө бус, харин бусдын тусын тулд өгөгддөг билээ. Иосеф үнэхээр бусдыг гэх өглөгч сэтгэлтэй хүн байсанд Бурхандаа талархъя. Иосеф үнэхээр зүүд ургаж чадахуйц үржил шимтэй зан чанартай хүн байжээ. Тэр үйлчилдэг Бурхан Эзэнийхээ өглөгч зан чанарыг дууриасан хүн байв.

Иосефийн ах нар Египетээс дүүрэн дүүрэн хүнстэй гарч явахдаа, энэ бүхнийг дүү нь өгснийг мэдээгүй. Тэгээд хоол хүнс нь дахин дуусаад, тэднийг Египетэд дахин ирэхэд нь Иосеф ах нараа шууд явуулчихалгүй, зоогт

урьжээ. Тэгээд Иосеф өөрийгөө илчлэв. Иосеф тэр олон жил гэрээ бэтгэртлээ санасандаа “...хажуудаа зогсож байсан бүгдийн өмнө сэтгэлээ барьж чадахгүйд хүрээд —Бүгдээрээ надаас зайлцгаа! хэмээн хашхирчээ. Иосефыг ах дүү нартаа өөрийгөө таниулахад түүний хамт хэн ч байсангүй” (Эхлэл 45:1) хэмээн Библи хэлдэг.

Тэгээд Иосеф асгартал уйлаад “Би Иосеф байна. Эцэг минь одоо хүртэл амьд сэрүүн байна уу? гэсэнд ах дүү нар нь түүнээс айн сандарснаасаа болоод хариулж чадсангүй. Иосеф ах нартаа, ‘Надад ойрт’ гэсэнд тэд ойртон очжээ. Тэгээд Иосеф ‘Би та нарын Египет уруу худалдсан тэр дүү Иосеф чинь байна. Та нар намайг энэ газар худалдсандаа бүү санаа зов, бүү харамс. Бурхан амийг аврахаар та нараас өмнө намайг илгээжээ’ ” (Эхлэл 41:3-5) гэж хэлжээ. Юу болсон бэ? Зүүд нь биелэхийг Иосеф бодитоор харжээ. Иосефийн зүүд нь

гагцхүү ах нарыг нь түүнд мөргүүлэхийн төлөө өгөгдсөн бус, харин Иосефийг чөлөөлөн аврагч болгохын төлөө өгөгдсөн байжээ. Иосеф ах нартайгаа Израилийн арван хоёр овог аймаг болсон юм. Иосеф тэднийг тэжээгээгүй байсан бол, Бурханы сонгосон хүмүүс өлсгөлөнд нэрвэгдээд үхчих боломжтой байжээ. Иосефт өгөгдсөн зүүдний нэгэн адил бидэнд өгөгддөг зүүд ч бусдын тусын тулд байдаг.

Би Иосеф ах нарынхаа өмнө мэлмэртэл уйлсан хэсгийг уншиж байхдаа: “Эзэн минь, зүүдтэй хүн л ийм өршөөнгүй байдаг байх” гэж бодсон юм. Иосеф зүүднээсээ зуурсан учраас л гэр бүлээ авраад зогсохгүй, Израилийн арван хоёр овгийг аварчээ. Тэгвэл чамд зүүд бий юу? Байгаа бол бүү тавь!

Иосефийн ах нар Канаанд эргэж очоод, хайртай хүү Иосеф нь амьдаар барахгүй, Египетийг захирч явааг аавдаа дуулгав. Аав нь мэл гайхан, цэл хөхрөөд, үхэхээсээ

өмнө үртэйгээ уулзъя гээд, өмнөө элч нарыг илгээн Иосефт хэл хүргээд, Гошен гэдэг газар уулздаг. Аав, хүү хоёрын учралыг төсөөлөшгүй. Ямар сайхан төгсгөл вэ? Гэхдээ түүх үүгээр дуусаагүй юм. Хамгийн сонирхолтой хэсэг нь болоогүй байна.

Иаков өөд болохоосоо өмнө үр хүүхдээ цуглуулж ерөөхдөө, Иосефийн хоёр хүүд хоёр дахин их ерөөлөө айлдан, эш үзүүлдэг. Яагаад? Яагаад гэвэл ууган хүүгийн эрхтэй хүү нь хоёр дахин их ерөөлийг өвлөдөг. Иосефийн хүү Манассе, Ефраим хоёр ч Амлагдсан газар - Канаанд маш том газар нутгийг өвлөн авчээ. Уг нь ууган хүүгийн эрхтэй хүү л ийм газрыг өвлөж авдаг боловч, газар нь хангалтай том байсан тул Иаковын ач нар ч газар хүлээн авчээ. Тэд хоёр дахин их ерөөлийг өвлөв! Хэрэв чи Бурханы өгсөн зүүднээс зуурч чадвал, Бурхан чамд ч хоёр дахин их ерөөлөө өгнө гэдэгт би итгэдэг.

Эцэст нь аавынхаа жишгээр Иосеф ч өөд болохдоо эш үзүүлж, амьдралаа ер бусын сайхнаар төгсгөдөг: “Иосеф бас Израилийн хөвгүүдээр тангараглуулан —Бурхан та нарт туслахаар заавал ирэх бөгөөд та нар ясыг минь эндээс авч яваарай гэж хэлэв” (Эхлэл 50:25).

Еврей 11:22 дээр Иосефийн тангарагын талаар маш сонирхолтой зүйл хэлдэг: “Итгэлээр Иосеф, нас барж байхдаа Израилийн хөвгүүдийн гэтлэлийн тухай дурдаж, өөрийнх нь ясыг хаана тавихыг зааварлажээ.”

Би үүнийг уншаад: “Яс ямар хамаатай юм бол?” гэж бодож билээ. Хэрэв би Еврей номыг бичсэн бол, Иосеф ах нараа уучилсан талаар эсвэл ямар сүрхий хүч хаттай хүн байсныг нь л бичих байсан байх. Бас хичнээн өршөөнгүй хүн байсныг нь л шагшин магтах байсан байх. Гэтэл Еврей 11 дээр Бурхан маань “Итгэлийн алдрын танхим” гэгддэг тэр бүх хүндтэй

үйл хэргийг үл тоогоод, оронд нь ясны тухай ярьжээ.

Иосеф өөрийнхөө ясны талаар хэлсэн учраас, Еврей 11 дээр Эзэн Иосефийн итгэлийг цохон тэмдэглэжээ. Тэгээд Матай 27 дээрээс Эзэн надад тун чухал нэг зүйлийг илчлэх хүртэл би энэ бүхний учрыг ойлгоогүй юм: “... булш нээгдэн нойрссон олон ариун хүний биес амилуулагдаж, Есүсийн амиллын дараа булшнуудаас гарч, ариун хотод орж, олонд харагджээ” (Матай 27:52-53).

Би дотроо Есүсийг амилуулагдах үед Түүнтэй хамт амилуулагдсан хүмүүсийн дунд Иосеф байсан гэдэгт битүүхэн итгэдэг. Иосеф тэдний дунд байна гэдгээ итгэлээр мэджээ. Тэр зүүдлэгч магадгүй: “Иерусалимын хавьцаа бусдаас арай эрт амилуулагдах хүмүүс байна. Аврагч маань үхлээс амилуулагдах үед тэд ч бас амилуулагдана. Тиймээс миний ясыг тэнд тавиарай. Би тэр

үед амилуулагдмаар байна” гэж хэлсэн байх гэж би дотроо төсөөлдөг.

Алсаа харах нь итгэл мөн! Иосеф зүүдлэхээ болиогүй - харин ч өөд болохдоо илүү том зүүд (мөрөөдөл) өвөрлөөд явжээ. Иосефийг өөд болсны дараа Израильчууд Египетээс гарахдаа, нэгэн онцгой ачаа тээгээд явжээ - ястай цүнх. Дэндүү чухал тээш учраас, ихэд нандигнав.

Тэр жигтэй цүнхийг харсан хүн: “Энд юу байгаа юм?” гэж сонирхоо л байх. “Чи итгэхгүй л байх. Гэхдээ энд яс байгаа!”

“Яс ий? Тоглоо байлгүй дээ. Хэнийх болоод ингэтэл нандигнана вэ? Үүгээр яах гэж байгаа юм?” “Энэ бол Иосефийн яс. Бид Иерусалимд оршуулах гэж байгаа юм.”

“Яагаад?”

“Яагаад гэж бүү асуу. Иосеф тэгж захисан юм.”

Иосеф яагаад ясаа Иерусалимд тавиулахыг

хүссэнийг Израильчууд мэдээгүй байх.
Гэхдээ л захиасыг нь биелүүлсэн. Зүүдлэгч
маань итгэлээрээ өөр нэг зүүдийг бүтээжээ -
Есүсийг амилуулагдах үед хамт амилуулагдах!
Тэгээд юу гээч? Иосеф ганцаас илүү дээл
хүлээж авсан юм. Тэр дээл нь аавынх нь
бэлэглэсэн өнгө өнгөөр алагласан дээлээс ч,
Фараоны өгсөн дээлээс ч чухал дээл байв:
“Учир нь газар дахь гэр болох майхан маань
нурах аваас бидэнд гараар баригдаагүй,
тэнгэрт мөнх байх, Бурханы барилга буйг
бид мэддэг. Тэнгэрийн орон гэрээ өмсөхийг
хүсэмжлэн, энд бид гасалцгаадаг. Бид
хувцасласан байх аваас нүцгэнээр олдохгүй.
Учир нь бид майхандаа байхдаа дарамтлагдан
гасалдаг. Учир нь үхдэг нь амиар залгигдахын
тулд бид тайлахыг бус, өмсөхийг хүсдэг юм”
(2Коринт 5:1-4).

Чи тэнгэрийн улсад Иосефтай уулзах үед
тэрбээр яг чам шиг зөвт байдлын тэнгэрлэг

дээлийг өмссөн байна. Мэдээж даавуун дээл боловч, хэзээ ч заваарахгүй учраас, хэзээ ч угаах шаардлагагүй. Дээл нь түүнд төгс таарсан. Тэгвэл чамд ч төгс таарах дээл Есүст байгаа.

Иосеф хамгийн сайхан дээлийг хүлээн авсан. Тэр зүүднээсээ зуурах эрэлхэг зоригтой, итгэлийн хүн байсан учраас, бүр өмнө хүлээн авчээ. Чи ч бас Иосефтай адилхан жижиг зүүдээр эхлээд, түүнийгээ зүрхэндээ ургуулсаар, хавьгүй том зүүдэнд хүрч чадна. Иосеф эхэндээ ах нарынхаа амийг аврах үзэгдэл үзсэн - зуурдын настай зүүдийг. Гэхдээ дараа нь өөрийнхөө амиллыг үзсэн - өнө мөнхийн настай зүүдийг.

Зүүдлэ. Энэ чинь чамайг ар араасаа илүү том алсын хараа дагуулсан илүү том алсын хараа руу хөтлөг. Хүмүүсийн зүүдийг бүү шүүмжил. Үүний оронд “Эзэн минь, би Таны зүүдийг зүүдлэмээр байна. Намайг бусдад туслах чадвартай болгох шүүн тунгаах

сүнслэг ухааныг өгөөч. Намайг зүүднээс цаадахыг харж, зүүдний ард байгаа Таныг харж чаддаг нэгэн болгооч. Намайг урам зоригтой болгооч” гэж залбир.

Чамд зүүд (дуудлага) бий юу? Би махан биеэс төрсөн зүүдний талаар бус, харин Ариун Сүнснээс төрсөн зүүдний талаар ярьж байна. Бурхан чиний алсын харааг биелүүлж, хүчин чадлыг чинь өсгөн нэмэхийг хүсдэг. Эзэний өгсөн зүйлийг дайсандаа бүү алд. Иосеф арван гурван жил сахин хамгаалсан юм шүү. Тиймээс зүүднээсээ Иосеф шиг л зуур!

БУРХАНЫ ҮГЭЭР БҮХ ДЭЛХИЙГ ДҮҮРГЭЭ . . .



Энэ бол Мэрилин, Сара хоёрын дуудлага. Биеийн болоод сүнслэг хэрэгцээний төлөө үйлчлэх нь Мэрилин Хиккигийн үйлчлэлийн зүрх юм.



- Илгээлтийн төсөл
- Хоол хүнсний хөтөлбөр
- Өнчин, орон гэргүй хүмүүст зориулсан халамжлийн үйлчлэл.



Мэрилин Хиккигийн
охин Сара Боулинг,
нөхөр Рииз Боулинг



- Дэлхий даяар цацагддаг зурагтын хөтөлбөр
- Цахим хуудас
- Залбирлын сүлжээ
- Илгээлтийн аян



Зүүднээсээ

ЗУУР!

Зүүдээр чинь дамжуулж Бурхан чамд ямар нэгэн зүйл хэлэх гээд байгаа юм шиг санагдаж байсан уу? Тэгээд сэртэл тэр зүүд чинь гарцаагүй биелнэ гэсэн гүн гүнзгий, гал халуун итгэл үнэмшил дотор чинь асахыг мэдэрч явсан уу?

Иосеф тэгсэн. Тэр Бурханд бүх юм боломжтой гэдгийг мэдэж байсан. Тэгээд Бурханаас өгсөн зүүд нь биелэхийг итгэлээрээ харсан. Бусдын боломжгүй гэдэг зүйлийг зүүдлэхээсээ бүү ай. Зүүдээ биелтэл атгасан Иосефийн нууцыг олж мэдээрэй!

P.O. Box 6598 • Englewood, CO 80155-6598
marilynandsarah.org • 1.888.637.4545